



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 4/75

Хажуу шинэ ус

Мал угаалгын ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66-р зүйлийн 66.1 дахь заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21-р зүйлийн 21.3.1, 21.4 дахь заалтууд, Аймгийн засаг даргын А/320 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал угаалгын ажлыг 2022 оны 08 дугаар сарын 02-ний өдрөөс эхлэн мэргэжлийн байгууллагын зөвлөмж, зохих заавар технологийн дагуу зохион байгуулж ажиллахыг Угтаал чандмань хоршооны малын эмч (Д. Амгалан)-д даалгасугай.

2. Малчид, мал бүхий иргэдэд мэдээлэл хүргэж ажиллахыг 1 дүгээр багийн Засаг дарга (Б.Мөнхтөгөлдөр), 2 дугаар багийн Засаг дарга (Г.Батчулуун), 3 дугаар багийн Засаг дарга (Б.Даваасүрэн) нарт даалгасугай.

3. Мал угаалгын ажилд хяналт тавьж, мэргэжлийн арга зүйгээр хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн Улсын байцаагч (А. Бямбадорж)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН